БАТЛАВ.

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА

.....

Ч.ЧИМИДСҮРЭН

2024 оны ..... сарын .....-ны өдөр

БАТЛАВ.

“ ББСБ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

Дугаар.....

Улаанбаатар хот

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

Энэхүү Хамтран ажиллах гэрээ /цаашид “гэрээ” гэх/-г Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 34.2 болон 34.4 дэх хэсгийг үндэслэн нэг талаас Татварын ерөнхий газар /цаашид “Татварын алба” гэх/, нөгөө талаас ... /цаашид “ББСБ”, хамтад нь “талууд” гэх/ нар нь дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Татварын алба нь Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг Монгол улсаас бусад улстай байгуулсан татварын зорилгоор мэдээлэл солилцох, түүний дотор автоматаар мэдээлэл солилцох олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцын хүрээнд мөн 18.2 дах хэсэг Монгол улсаас бусад улстай байгуулсан хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор эрх бүхий этгээд нь гадаад улсын эрх бүхий этгээдтэй зөвхөн татварын асуудлаар харилцан мэдээлэл солилцох болон энэ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасны дагуу татвар төлөгчийн талаар хөндлөнгийн мэдээлэл цуглуулж, хөндлөнгийн мэдээллийн санг бүрдүүлж, мэдээллийг татварын хяналт шалгалт, татвар ногдуулалт, хураалт болон татвар төлөгчийн эрсдэл, бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор хуульд заасны дагуу татвар төлөгчийн мэдээллийг ББСБ-аас гаргуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. ББСБ нь гэрээний 1 дүгээр хавсралтаар баталсан мэдээллийг Татварын албанд хүргүүлнэ.

1.3. Талууд гэрээний 2 дугаар хавсралтаар гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах ажилтнуудын мэдээллийг баталгаажуулна. Тус хавсралтад өөрчлөлт орсон тухай бүр гэрээний нөгөө талд мэдэгдэнэ.

ХОЁР. ТАТВАРЫН АЛБАНЫ ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Татвар төлөгчийн тус ББСБ-д эзэмшиж буй дансны мэдээлэл болон уг данстай холбоотой хамтран эзэмшигчийн мэдээллийг хууль, гэрээнд заасны дагуу ББСБ-аас гаргуулан авах.

2.2. ББСБ-аас ирүүлсэн татвар төлөгч, түүний дансны мэдээллийг аливаа хэлбэрээр гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй байх, зөвхөн хуулийн хүрээнд татварын зорилгоор ашиглах.

2.3. ББСБ-аас мэдээлэл хүлээн авах татварын албаны техникийн болон технологийн шаардлага хангасан мэдээллийн системийг бий болгох, цахим сангийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах.

2.4. Мэдээлэл хүлээн авах үйл ажиллагаанд тасалдал гарсан, мэдээлэл хүлээн аваагүй зэрэг тохиолдолд ББСБ-д тухай бүр нь мэдэгдэж, үүссэн асуудлыг нэн даруй шийдвэрлэх, мэдээллийг бүрэн ирүүлэх арга хэмжээ авах.

2.5. Системд техникийн өргөтгөл болон системийн шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай үед ББСБ-д 5 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

2.6. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг гэрээнд оролцогч нөгөө талаас шаардах.

2.7. ББСБ-ын харилцагч болон гуравдагч этгээд гомдол гаргасан болон шаардлагатай тохиолдолд мэдэгдлийн эх хувийг гаргуулах хүсэлтийн дагуу татварын байгууллага нь мэдэгдлийн эх хувийг ажлын 5 хоногийн дотор ББСБ-д өгнө.

ГУРАВ. ББСБ-ЫН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Татвар төлөгчийн дансны мэдээллийг хүлээн авах цахим сан, мэдээлэл хүлээн авах системийн аюулгүй ажиллагааны байдлыг хангасан эсэх талаар татварын албанаас мэдээлэл авах, шаардлагатай арга хэмжээг авахыг шаардах.

3.2. Татвар төлөгчийн ББСБ-д шинээр төлбөр тооцоо, хадгаламжийн болон бусад төрлийн данс нээсэн, хаасан, эсхүл өмнө нээсэн дансны мэдээлэлд өөрчлөлт хийлгэсэн бол мэдээллийг дараа сарын 10-ны өдрийн дотор татварын албанд хүргүүлнэ.

3.3. Энэхүү гэрээний 3.2-т заасан хугацаа нь амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр таарсан тохиолдолд дараагийн ажлын өдөрт шилжүүлэх.

3.4. Татварын алба нь энэ гэрээний 3.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй, шаардлагатай арга хэмжээ аваагүй гэж үзэх үндэслэл гарсан тохиолдолд гэрээний эрх, үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

3.5. Гэрээний 1 дүгээр хавсралтад заасан мэдээллийг дутуу, алдаатай хүргүүлсэн тохиолдолд нөгөө талд мэдэгдэж түүнийг засах, бүрэн хүргүүлэх арга хэмжээ авахыг шаардах.

3.6. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг гэрээнд оролцогч нөгөө талаас шаардах.

3.7. Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.1, 34.4.3-д заасан мэдээллийг татварын албанаас тухай бүр албан бичгээр болон тоон гарын үсгээр баталгаажсан цахим хүсэлтийг үндэслэн цахим хэлбэрээр тус тус гаргаж өгөх.

3.8.Татварын ерөнхий хуулийн 15 дугаар зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацаанд хамаарах энэ хуулийн 34.4.3-д заасан мэдээллийг татварын албанд хүргүүлэх.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

4.1.ББСБ нь гэрээний 3.2, 3.7-д заасан мэдээллийг татварын албанд хүргүүлэх үүргээ биелүүлээгүй нь Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл болно.

4.2.Хүлээн авсан мэдээллийг боловсруулж, ашиглах явцад холбогдох хууль тогтоомж зөрчигдсөн байж болзошгүй тохиолдолд илэрсэн зөрчил, дутагдлыг харилцан мэдээлж, зөрчлийг арилгах талаар хамтран ажиллана.

4.3.Энэхүү гэрээний дагуу ирүүлсэн мэдээллийг гэрээнд оролцогч талууд чандлан хадгалах үүрэгтэй бөгөөд энэ гэрээ болон хуульд зааснаас бусад ямарч зорилгоор ашиглах, гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр дамжуулахыг хатуу хориглох ба мэдээллийн нууцыг хугацаагүйгээр хадгалах үүрэгтэй.

4.4.Гэрээг зөрчсөний улмаас бусдад учирсан аливаа хохирлыг тухайн зөрчлийг гаргасан тал бүрэн хариуцах үүрэгтэй.

4.5.Энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс мэдээлэлд дурдагдсан этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тал хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

5.1.Энэхүү гэрээний нөхцөл нь хоёр талд адил хүчинтэй бөгөөд талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

5.2.Гэрээг Монгол хэл дээр 2 хувь үйлдэх бөгөөд талууд тус бүр нэг хувийг хадгална.

5.3.Гэрээ болон гэрээний хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулахаар аль нэг талын гаргасан саналыг нөгөө тал хүлээн зөвшөөрсөн бол нэмэлт, өөрчлөлтийг гэрээ байгуулах замаар шийдвэрлэнэ.

5.4.Гэрээний хавсралт, нэмэлт өөрчлөлтийн гэрээ нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд гэрээний адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

5.5.Энэхүү гэрээг 2024 оны .... дугаар сарын ...-ны өдрөөс 2027 оны .... дугаар сарын ....-ны өдрийг хүртэл 3 жилийн хугацаатай байгуулав.

5.6.Талууд хамтран ажиллах гэрээний хугацааг сунгах, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах талаар албан бичгээр хүсэлт гаргаагүй тохиолдолд тус гэрээг хүчин төгөлдөр хэвээр үлдээж, ижил нөхцөлөөр анх байгуулагдсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

5.7.Талууд хуульд заасны дагуу эсхүл харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

5.8.Талууд гэрээг цуцалсан нь хуулийн дагуу мэдээлэл гаргуулахтай холбогдсон эрх, үүргийг хязгаарлахгүй болно.

5.9.Энэхүү гэрээнд дурдаагүй асуудлыг шийдвэрлэхэд талууд холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

5.10.Энэхүү гэрээнээс үүдэн гарсан маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд ийнхүү зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:

ББСБ-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

.....

.....

.....

2024 оны …. дугаар сарын .... ны
өдрийн ..... тоот гэрээний
1 дүгээр хавсралт

ББСБ-аас Татварын ерөнхий газарт өгөх мэдээлэл

1. Зээлийн болон итгэлцлийн дансны мэдээлэл
   1.1. Мэдээллийн төрөл /данс нээсэн, хаасан, дансны мэдээлэлд өөрчлөлт орсон гэх мэт/
   1.2. Дансны дугаар
   1.3. Данс нээсэн огноо
   1.4. Данс эзэмшигч нь иргэн бол:
      1.4.1. Данс эзэмшигчийн регистрийн дугаар / гадаадын иргэн бол регистрийн дугаар /ID дугаар/, харьяалалгүй иргэний хувьд оршин суух үнэмлэхийн дугаар/
      1.4.2. Данс эзэмшигчийн эцэг/эхийн нэр
      1.4.3. Данс эзэмшигчийн нэр
   1.5. Данс эзэмшигч нь хуулийн этгээд бол:
      1.5.1. Данс эзэмшигч хуулийн этгээдийн регистрийн дугаар
      1.5.2. Данс эзэмшигч хуулийн этгээдийн оноосон нэр
      1.5.3. Данс эзэмшигч хуулийн этгээдийн хэлбэр /ХК, ХХК, ТББ гэх мэт/
   1.6. Эзэмшигчийн үндсэн харьяалал
   1.7. Хамтран эзэмшигчийн регистрийн дугаар
   1.8. Хамтран эзэмшигчийн овог
   1.9. Хамтран эзэмшигчийн нэр/оноосон нэр
   1.10. Хамтран эзэмшигчийн үндсэн харьяалал
   1.11. Дансны төрөл
   1.12. Дансны валютын төрөл
   1.13. Тухайн жилд дансаар гүйлгээ хийгдсэн эсэх /тийм,үгүй/
   1.14. Дансны гүйлгээний мэдээлэл /Татварын албанаас ирүүлсэн хугацаанд хамаарах/
   1.15. Дансны төлөв
   1.16. Данс хаасан огноо

2024 оны …. дугаар сарын .... ны
өдрийн ..... тоот гэрээний
2 дугаар хавсралт

Талууд мэдээлэл солилцох үйл ажиллагаатай холбоотой системийн асуудлаар дараах ажилтнуудтай хамтран ажиллана.

№	Холбогдох үйл ажиллагаа	Татварын Ерөнхий Газар	ББСБ
1	Мэдээллийг харилцан солилцох ажилтан	Газар: Эрсдэлийн удирдлагын газар Ш.Мөнхзаяа Албан тушаал: Татварын улсын байцаагч Утас: 9191-8934	
2	Гэрээ хэлэлцээр хариуцсан мэргэжилтэн	Газар: Эрсдэлийн удирдлагын газар Ш.Мөнхзаяа Албан тушаал: Татварын улсын байцаагч Утас: 9191-8934	
3	Програм хангамж, мэдээлэл солилцох систем хариуцсан	Хэлтэс: МТТ Т.Ганхөлөг Албан тушаал: Програмист Утас: 9494-9221	